

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Сайншанд сумын 1 дүгээр багийн гадна цэвэр усны шугамын ажил:

А. Ажил гүйцэтгэх хугацааны график хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоог тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Үнийн саналд зураг төсвийн үнийг **5 000 000 /Таван сая/** төгрөгөөр, захиалагчийн хяналтын зардлыг талбайн угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгийн 2%-иар, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгаж ирүүлнэ.

Г. Төсөв зохиохдоо Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 30 тоот тушаалаар батлагдсан төсөв зохиох дүрэм, БХБ сайдын 2006 оны 142 тоот тушаалаар батлагдсан Барилгын сантехникийн ажлын төсвийн суурь норм, 2021 оны 229 тоот тушаалаар батлагдсан Барилгын сантехникийн ажлын төсвийн суурь норм нэмэлт №8-ыг мөрдлөг болгоно.

Д. Авто тээврийн зардлыг ЗТХ сайдын 2019 оны 256 тоот тушаалаар батлагдсан авто машинаар ачаа тээвэрлэх жишиг тарифаар тооцно.

Е. ЗТБХБС-ын 2012 оны 18 дугаар тушаалаар машин механизмын зардлыг тооцож ирүүлнэ.

Ё. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлнэ.

Ж. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах.

1. Газар шорооны ажил

Газар шорооны ажил гүйцэтгэх үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж ажиллана. Шугам урсралтын ажил гүйцэтгэж дууссаны дараа бүрэн цэвэрлэж орчмын газрыг хэвийн байдалд оруулж өгнө.

2. Газар шорооны ажил

Шугам угсралтын ажлыг гүйцэтгэхдээ хангагч байгууллагын техникийн нөхцөлийн дагуу **ЦУХ-1** огтлолцол авч **ЦУХ-2,3,4,5** шинээр үүсгэн байгуулж Ф90мм голчтой технологийн шаардлага хангасан хуванцар хоолойгоор хөлдөлтийн гүнээс доош холболтыг хийнэ.

Шугам угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 40-01-14 Ариутгах татуурга, гадна сүлжээ ба байгууламж, БД 40-102-16 Ус хангамж ариутгах татуургыг сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах үндсэн журам, MNS 0907:1982 Цэвэр ус ариутгах татуургын шугамын худгийн угсармал төмөр бетон хийцийн тус тус баримтлан хуванцар яндан хоолой болон цайрдсан ган яндан хоолойг угсран пенополиуретан дулаалга хийж өгнө. Ус хангамжийн хаалт болон ус буулгагч тавьж хуурай хөрсөнд цэвэр ус байрлуулах дугуй худаг байршуулна.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилга байгууламжийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинэжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинэжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлыг гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
7. Барилга байгууламжийн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулхаар болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
9. Хэрвээ талбайн тохижилт, шугам сүлжээний зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхойгүй хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
12. Монгол улсын "Барилгын тухай" хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т /14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-т /14.4-т заасны дагуу /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/ гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага чанарыг баталгаа гаргаж өгнө.
13. тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

САЙНШАНД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮҮЦЭТГЭГ



Ш.ЧУЛУУНЦЭЦЭГ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

САЙНШАНД СУМЫН
ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

A handwritten signature in black ink, appearing to read 'Б. Энхманлай'.

Б.ЭНХМАНЛАЙ